ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр Дугаар А/404 Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн тушаах нь:

1. “Далд уурхайн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр, “Ил уурхайн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг хоёрдугаар, “Ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Далд, ил уурхай, ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрт хийх хяналт шалгалтыг батлагдсан хяналтын хуудасны дагуу зохион байгуулахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа А.Дашням)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

1225013163

D:\2025\3,4\tushaal 3,4-2025.docx

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025... оны .10. дугаар сарын .10.-ны өдрийн
А/.. дүгээр тушаалын .01. дүгээр хавсралт
/404

## ДАЛД УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

### 1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

| | | |
|---|---|---|
| Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж: | | |
| Шалгуулагч этгээдийн нэр: | | |
| Регистрийн дугаар: | | |
| Объектын нэр, хаяг, солбицол: | | |
| Байгуулагдсан огноо: | | |
| Үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо: | | |
| Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар: | | |
| Хяналт шалгалт хийсэн огноо: | Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн огноо: | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо: |
| | | |
| Шаардлага хангасан асуултын тоо: | /………/……………………/ | /………/……………………/ |
| Шаардлага хангаагүй нийт оноо: | /………/……………………/ | /………/……………………/ |
| Хууль сахин мөрдөлтийн хувь: | /………/……………………/ | /………/……………………/ |
| Эрсдэл үүсэх магадлалын хувь: | /………/……………………/ | /………/……………………/ |
| Эрсдэл үүсэх магадлал: | *I их, дунд, бага I* | *I их, дунд, бага I* |

### 2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

| № | Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт | Асуултууд | Батлагдсан оноо: Шаардлага хангаагүй | Батлагдсан оноо: Шаардлага хангасан | Авсан оноо | Гүйцэтгэлийн хяналт шалгалт |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ | | | | |
| 1 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 34 дүгээр зүйлийн 34.2.5 дахь заалт | Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн эсэх? | 0 | 10 | | |
| 2 | | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдсан эсэх? | 0 | 10 | | |
| 3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх? | 0 | 10 | | |
| 4 | Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас | Зааврын дагуу боловсруулсан эсэх? | 0 | 10 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.12 дахь хэсэгт | | | | | |
| 5 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.4 дэх хэсэгт | Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээгээр төлөвлөж, зарцуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 6 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 10.3.5, 10.3.6 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам"-ын 2 дугаар хавсралтын Хуулийн этгээдийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, 2 а, б, 3, 5 а, б, в, 6 г, 7, 8 а, б, 9 б, 10, 12 дугаар зүйл. | Хуулийн этгээд нь болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангасан эсэх? | 0 | 10 | | |
| 7 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ын 2 дугаар хавсралтын 1.4, 5.3.2, 5.3.3 дахь заалт | Болзошгүй гамшгийн үед өөрийн байгууллагад байгаа материал хэрэгслийг гаргаж зарцуулах нөөцтэй эсэх? | 0 | 10 | | |
| 8 | ОБЕГ-ын даргын 2016 оны А/75 дугаар тушаалын 2 дугаар хавсралт | "Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө"-тэй эсэх? | 0 | 10 | | |
| 9 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.3.7, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт | Гамшгаас хамгаалах сургалтыг тогтоосон хугацаанд зохион байгуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 10 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. | Болзошгүй гамшгийн үед дайчлагдан ажиллах танай байгууллагын ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг хангасан эсэх? | 0 | 10 | | |
| Нийт оноо | | | 0 | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 4 дүгээр зүйл | Уурхай нь орон тооны, орон тооны бус, уурхай дундын, гэрээт гэх мэт аль нэг хэлбэрийн аврах нэгжтэй байх | 0 | 4 | | |
| 2 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 10 дугаар зүйл | Уурхайд шинээр ажилд орж байгаа ажилтанд ажлын байр, уурхайгаас гарах үндсэн болон нөөц гарц, малталтуудыг танилцуулсан байна.<br>а) Нийт ажилтнуудад нөөц гарцыг 12 сар тутамд танилцуулах бөгөөд нөөц гарц өөрчлөгдвөл нэн даруй танилцуулна. Ажилтан үндсэн болон нөөц гарцтай танилцсан тухай энэ дүрмийн 2.в-д заасны дагуу тэмдэглэл хийнэ.<br>б) Үндсэн малталтуудын уулзварт уурхайгаас гарах, эсхүл хоргодох байрны чиглэл, зайг заасан гэрэлтдэг цацруулагчтай тэмдэг байршуулна. | 0 | 4 | | |
| 3 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 11 дүгээр зүйл | Уурхайн ажилтан бүрийг өөрийгөө аврах тусгаарлах багаар хангах бөгөөд ажилтан бүр заавал биедээ авч явах ёстой. Газрын доорх ажилтнуудын тооноос 10 %-р илүү тооны багийг бэлэн байдалд байлгана. Баг ашиглах шалгалтыг 12 сар тутам ажилтнаас авна. Ажилтан бүр уурхайд орохдоо багын бүрэн бүтэн байдалд биечлэн үзлэг хийнэ. Багийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтоосон хугацаанд аврах нэгжийн мэргэжилтэн шалгаж, акт үйлдэнэ. | 0 | 4 | | |
| 4 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 12 дугаар зүйл | 12. Газрын дээрх болон доорх үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшинг тогтоолгосон, уул, уурхайн мэргэжлээр бакалавраас доошгүй боловсрол эзэмшсэн, эсхүл далд уурхайд 8-аас доошгүй жил ажилласан хүн удирдана. | 0 | 4 | | |
| 5 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 13 дугаар зүйл | “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-д гарсан өөрчлөлтийг тухай бүр бүх ажилтнуудад заавал танилцуулж, энэ дүрмийн | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2.в-д заасны дагуу бүртгэж, гарын үсэг зуруулна. Хэрэв танилцуулж, гарын үсэг зуруулаагүй бол тухайн ажилтныг ажиллуулахыг хориглоно. Уурхайд осол гарсныг мэдээлэх дохиоллын системтэй байна. | | | | |
| 6 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 70 дугаар зүйл | Босоо амны нэвтрэлт, гүнзгийрэлтийн үед өргөх төхөөрөмж бүр өөр хоорондоо хамааралгүй 2-оос доошгүй дохиоллын системээр тоноглогдсон байна. Мөргөцөг, тавцан дээр нэгэн зэрэг ажиллаж байх үед тэдгээрээс өгөх дохионууд ялгаатай байна. | 0 | 4 | | |
| 7 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 99 дүгээр зүйл | Ажилтан ажиллах малталтын агаарт хүчилтөрөгчийн агуулга эзлэхүүнээрээ 20 %-с доошгүй, нүүрс хүчлийн давхар исэл доорх хэмжээнээс дээшгүй байна. Үүнд:<br>а)ажлын байранд 0.5 %;<br>б)уурхайгаас гарах агаарын ерөнхий урсгалтай малталтад<br>0.75 %;<br>в)нурсан малталтыг нэвтрэх ба сэргээх ажлын үед 1 % тус тус байна. | 0 | 4 | | |
| 8 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 101 дүгээр зүйл | Малталтуудад өгч байгаа агаарын температур $+2^{0}C$-ээс багагүй байна. Зөвхөн агаар оруулах зориулалттай, тоноглолгүй малталтад энэ заалт хамаарахгүй. | 0 | 4 | | |
| 9 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 105 дугаар зүйл | Уурхай нь агааржуулалтын тусгай системтэй байна. | 0 | 4 | | |
| 10 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 111 дүгээр зүйл | Тусгай зориулалтын бүх малталтуудыг цэвэр агаарын тусдаа урсгалаар агааржуулах ба бохирдсон агаар уурхайгаас эсхүл хэсгээс гарах агаарын урсгалтай шууд холбогдоно.<br>-Агаарын урсгал дахь шатамхай хийн агуулга 0.5%-аас хэтрэхгүй, бусад хорт хий байхгүй байвал уурхайн агаар гадагш гарч буй урсгалын замд дээрх байруудыг байгуулж болно. | 0 | 4 | | |
| 11 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 115 дугаар зүйл | Олборлолтын хэсэг тус бүрийг бие, биеэс нь үл хамааруулан, агааржуулалтын ерөнхий урсгалаас агааржуулах ба | 0 | 4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгнийх нь агааржуулалтыг өөрчлөхөд бусдадаа нөлөөлөхөөргүй байна.<br>-Зарим тохиолдолд хоёр олборлолтын малталтуудыг дараалуулан агааржуулж болно. Тэгэхдээ хоёр дахь мөргөцөгт цэвэр агаар өгөх боломжийг хангахдаа тоос дарах арга хэмжээг авна.<br>-Шаардлагатай тохиолдолд олборлолтын мөргөцгийг зөөврийн сэнсээр агааржуулна. | | | | |
| 12 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 118 дугаар зүйл | Орд газрын аль нэг судал, биет, давхаргад хортой болон шатах хий илэрсэн байвал хий тоосны аюултай уурхайд багтаана. | 0 | 4 | | | |
| 13 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 128 дугаар зүйл | Уурхайг тасралтгүй ажиллагаатай төв агааржуулах байгууламжаар агааржуулна.<br>-Төв агааржуулах байгууламж нь нэг буюу хэд хэдэн сэнстэй байж болно.<br>-Зарим тохиолдолд уурхайн ерөнхий агааржуулалтын сэнсийг газрын доор байрлуулж болно. | 0 | 4 | | | |
| 14 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 144 дүгээр зүйл | Уурхайд гурван жилд нэгээс доошгүй удаа уурхайн агаарын даралтын хэмжилтийн зураглалыг хийж гүйцэтгэнэ. Эквивалент нүх нь 1 $м^2$-аас бага, хүнд агааржуулалттай уурхайд агаарын даралтын хэмжилтийн зураглалыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Агаарын даралтын хэмжилтийн зураглалын үр дүнгээр уурхайн эрх бүхий албан тушаалтан илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батална. | 0 | 4 | | | |
| 15 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 146 дугаар зүйл | Бэлтгэл ба огтолгооны малталтуудыг бүрэн нэвтэрч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангасны дараа үндсэн олборлолтыг эхэлнэ. | 0 | 4 | | | |
| 16 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 249 дүгээр зүйл | Өөрөө явагч машиныг /цаашид машин гэх/ ашиглах, үйлчилгээ хийх журам болон эдгээр машины шатах тослох материалын агуулах, засвар үйлчилгээ хийх, цэнэглэх, угааж цэвэрлэх байр болон зогсоолыг тусгай /төслөөр/ зураг төсөлд тусгасан байна. | 0 | 4 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 339 дүгээр зүйл | Уурхайн өргөх төхөөрөмжид ашиглах ган татлага нь үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй байна. Ган татлагыг холбогдох мэргэжлийн байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулж ашиглана. Ган татлагын хийцийг ашиглалтын шаардлагад нийцүүлэн сонгоно. | 0 | 4 | | |
| 18 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 392 дугаар зүйл | Өргөх машин бүр бүтэн ажиллагаатай дараах хэмжих хэрэгслүүдтэй байх ёстой. Үүнд:<br>а)хөдөлгөөний чиглэл, хурдыг бүртгэх багаж;<br>б)ачааллын болон цахилгаан динамик тоормосны хэлхээний вольтметр, амперметр;<br>в)тоормосны систем дэх тос ба хийн даралт заах манометр. | 0 | 4 | | |
| 19 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 397 дугаар зүйл | Мэргэжлийн тохируулгын баг, уурхайн засвар үйлчилгээний мэргэжилтнүүдтэй хамтарч өргөх төхөөрөмжийг ашиглалтад өгөхийн өмнө болон цаашид жилд нэг удаа шалгалт, тохируулгын ажил хийнэ. Энэ шаардлага ачааны эргүүлэгт хамаарахгүй.<br>-Шалгалт, тохируулга хийснээс хойш 6 сарын дараа засвар хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар ахлуулсан баг өргөх төхөөрөмжийн техникийн үзлэг, туршилтыг хийнэ.<br>-Шинээр ажилд оруулж байгаа тоормосны төхөөрөмж, түүний голуудыг үл эвдэх аргаар шалгана. Цаашдаа энэ шалгалтыг 3 жил тутам хийнэ.<br>-Өргөх төхөөрөмжид шалгалт, тохируулгын тэмдэглэл, техникийн үзлэг туршилтын актыг үйлдэн үйлдвэрийн засвар хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар батлуулна.<br>-Шалгалт, тохируулгын ажлын үед 330 дугаар заалттай хамруулан өргөх машины суурилуулалт, чиглүүлэгчийн байршил, элэгдэлд маркшейдерийн бүрэн шалгалт хийж акт үйлдэнэ. | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 398 дугаар зүйл | Өргөх төхөөрөмж бүрд дараах бичиг баримтууд байна. Энэ нь электрон хэлбэрээр байж болно. Үүнд:<br>а)өргөх машин түүний редуктор, өргөх сав, өлгөх болон шүхрийн тоноглолын техникийн паспорт;<br>б)үндсэн хэмжээснүүдийн заасан тоормосны төхөөрөмжийн нарийвчилсан схем;<br>в)цахилгааны зарчмын схем;<br>г)хяналтын хэмжээснүүдийг заасан шүхрийн төхөөрөмжийн схем;<br>д)өргөх төхөөрөмжийн операторын заавар;<br>е)"Өргөх төхөөрөмжийн үзлэгийн дүн бүртгэх дэвтэр", "Өргөх төхөөрөмжийн ган татлагын үзлэгийн дүн, зарцуулалтыг бүртгэх дэвтэр", "Өргөх төхөөрөмжийн операторын ээлж хүлээлцэх дэвтэр";<br>ё)өргөх төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг хийх хугацааг заасан, уурхайн эрх бүхий албан тушаалтны баталсан ажлын хуваарь;<br>ж)өргөх төхөөрөмжийн үзлэг болон засварын заавар. | 0 | 4 | | |
| 21 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 405 дугаар зүйл | Уурхай нь тусгаарлалтын журамтай байх бөгөөд түүнийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана. Энэхүү журамд тусгаарлалтын ангилал, төрөл, цоож пайзны систем гэх мэт бусад шаардлагатай асуудлыг тусгасан байна. | 0 | 4 | | |
| 22 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 475 дугаар зүйл | Уурхай нь доорх төрлийн холбоо, дохиоллуудыг дангаар нь болон хослуулж ашиглана:<br>а)утсан болон радио харилцааны систем;<br>б)уурхайн ослын дохиоллын систем;<br>в)технологийн хэсгүүдэд хэрэглэх анхааруулах болон ажлын дохиоллын систем /өргөх, тээвэрлэх, мөргөцөгт г.м/;<br>г)уурхайн диспетчерийн холбооны систем. | 0 | 4 | | |
| 23 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 532 дугаар зүйл | Уурхайн ажлын нөлөөгөөр газрын гадаргууд үүссэн ан цав, нүх, цөмрөлөөр дамжин ус уурхайн малталт руу урсан орохоос хамгаалсан | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | далан, суваг шуудуу татна. | | | | |
| 24 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 545 дугаар зүйл | Уурхай бүр “Агаарын тоосны шинжилгээний бүртгэл” хөтөлнө. | 0 | 4 | | |
| 25 | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн 76 дугаар зүйл | Тэсэлгээний ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлын төсөл, паспортын дагуу "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн холбогдох заалтыг баримтлан хийж гүйцэтгэнэ. Тэсэлгээний ажлын төсөл, паспортод заасан зүйлс зөрчигдөх, өрөмдлөгийн ажил дуусаагүй, уул тээврийн машин механизм, тоног төхөөрөмжийг аюултай бүсийн хязгаараас гаргаагүй байх зэрэг урьдчилсан бэлтгэл ажил хангагдаагүй үед тэсэлгээний ажил явуулахыг хориглоно. | 0 | 4 | | |
| Нийт оноо | | | 0 | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ДАЛД УУРХАЙН АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР | | | | | | |
| 2.2 дугаар зүйл | | Үндсэн төлөвлөлт дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: | | | | |
| 1 | 2.2.1. дүгээр зүйл | уурхайн товч танилцуулга, ямар ашигт малтмал олборлодог, ашиглалтын систем, бэхэлгээ, агааржуулалт, ус таталт, тохиолдож болзошгүй аюул, ослын тухай; | 0 | 4 | | |
| 2 | 2.2.2. дугаар зүйл | шуурхай ажиллагааг зохион байгуулах хэсэг; | 0 | 4 | | |
| 3 | 2.2.3. дугаар зүйл | ослын үеийн удирдагчийг томилсон тухай уурхайн даргын тушаал; | 0 | 4 | | |
| 4 | 2.2.4. дүгээр зүйл | уурхайн аврах нэгж байгуулсан тухай даргын тушаал; | 0 | 4 | | |
| 5 | 2.2.5. дугаар зүйл | аюул, ослын үед уурхайн инженер техникийн ажилтан, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг; | 0 | 4 | | |
| 6 | 2.2.6. дугаар зүйл | аюул, осол гарсан тухай яаралтай мэдэгдэх байгууллага, хариуцлагатай ажилтны дэс дараалал, нэрс, утасны дугаар, гэрийн хаяг; | 0 | 4 | | |
| 7 | 2.2.7. дугаар зүйл | аюул, осол тохиолдсон үед уурхайн ажилтнуудын үүрэг | 0 | 4 | | |
| 2.3 дугаар зүйл | | Ажлын зурагт дараах зургууд орно. Үүнд: | | | | |
| 8 | 2.3.1. дүгээр зүйл | уурхайн газрын дээрх барилга, байгууламж, зам, талбай, босоо, налуу ам, мөргөцөг, малталт, нөөц гарц, цугларах талбайн байрлалыг заасан уурхайн ерөнхий дэвсгэр зураг; | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | 2.3.2 дугаар зүйл | уурхайн агааржуулалтын зураг; (агааржуулах төхөөрөмжийн (вентилятор) шахах болон сорох горимын үед); Энэ зураг дээр уурхайн малталтын агаарын урсгалын чиглэл, хэмжээ, цэвэр болон бохирдсон агаарын урсгал, өөрийгөө хамгаалах баг хадгалах байр, хоргодох байр, хэсгийн зориулалттай агааржуулах төхөөрөмж, агааржуулалтын хаалга, хаалт бусад байгууламж, суурин утас, нөөц гарц зэргийг тодорхой дүрсэлсэн байна. | 0 | 4 | | |
| 10 | 2.3.3 дугаар зүйл | уурхайн гал түймрээс хамгаалах усан хангамжийн зураг; Энэ зураг дээр гал унтраах зориулалттай шугам, хоолой, тоног төхөөрөмж, гал түймрийн хаалт, хамгаалалт, агуулахын байрлал, даралттай усны хоолойн сүүлийн цэг дээрх даралт мөн газрын дээрх гал түймэр унтраах тоног төхөөрөмж, шугам, хоолойн зураг, тэдгээрийн байрлал зэргийг дүрсэлнэ. | 0 | 4 | | |
| 11 | 2.3.4 дүгээр зүйл | уурхайн цахилгаан хангамжийн зураг; Бүх зургууд масштабтай байх ба зураглалыг уурхайн уулын ажлын давхарга тус бүрээр хийж гүйцэтгэнэ. | 0 | 4 | | |
| 2.4 дүгээр зүйл | | Хавсралт хэсэгт уурхайн аюулын эсрэг бэлэн байдлыг шалгасан акт (төрөл тус бүрээр), комиссын дүгнэлтийг хавсаргасан байна. | | | | |
| 12 | Уурхайн хүдрийн биетийн жигүүрийн блокоос гарах бэлтгэл гарцуудыг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 13 | Ажилтнууд шүүгч багтай ажлын байрнаасаа цэвэр агаарын урсгалтай малталт руу гарах хугацааг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 14 | Аврагчдын тусгаарлагч шүүгч багтай алслагдсан мөргөцөгөөс цэвэр агаарын урсгалтай малталт руу гарах хугацааг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 15 | Уурхайн аюулын дохиолол, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн ажиллагаа, ажилтнуудын дохиогоор ажиллаж төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 16 | Уурхайн агааржуулах төхөөрөмжийн тогтвортой ажиллагаа, агаарын урсгалын чиглэлийг өөрчилж шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 17 | Уурхайн гал түймэр унтраах тоног төхөөрөмжийн ажиллагаа, гал түймэр эсэргүүцэх агуулах, тэдгээрийн иж бүрдлийг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 18 | Уурхайн гүний төв усан сангийн усны насосын ажиллагааг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 19 | Уурхайн аврах нэгжийг шалгасан АКТ | | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20 | Уурхайн аюулын эсрэг бэлэн байдлын дүгнэлт | | 0 | 4 | | |
| 21 | 4.7.1 дүгээр зүйл | уурхайн бүх хэсгүүдэд аюул, осол гарсан тухай мэдээлэх журам; | 0 | 4 | | |
| 22 | 4.7.2 дугаар зүйл | ослын голомтоос хүмүүсийг гаргах зам; | 0 | 4 | | |
| 23 | 4.7.3 дугаар зүйл | аврагчдын явах зам; | 0 | 4 | | |
| 24 | 4.7.4 дүгээр зүйл | аюул, ослын үед цахилгаан гүйдлийг бүрмөсөн буюу хэсэгчлэн таслах арга хэмжээ; | 0 | 4 | | |
| 25 | 4.7.5 дугаар зүйл | аюул, ослын үед тусгай үүрэг гүйцэтгэх ажилтныг томилж, аюулгүй байдлыг сахиулах, бүртгэх, хяналт тавих. | 0 | 4 | | |
| НИЙТ ОНОО | | | 0 | 100 | | |

Шаардлага хангаагүй нийт оноо:
>=50% Их эрсдэлтэй
[30%-49%] Дунд эрсдэлтэй
<=29% Бага эрсдэлтэй

## 3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

| Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг | Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| (албан тушаал) | (албан тушаал) | (албан тушаал) |
| (овог, нэр) | (овог, нэр) | (овог, нэр) |
| (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) |

ТАЙЛБАР:
..............................................................................................................................................................
..............................................................................................................................................................
..............................................................................................................................................................
..........................

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025... оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
А/404 дүгээр тушаалын 02 дугаар хавсралт

ИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

| | | |
|---|---|---|
| Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж: | | |
| Шалгуулагч этгээдийн нэр: | | |
| Регистрийн дугаар: | | |
| Объектын нэр, хаяг, солбицол: | | |
| Байгуулагдсан огноо: | | |
| Үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо: | | |
| Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар: | | |
| Хяналт шалгалт хийсэн огноо: | Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн огноо: | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо: |
| | | |
| Шаардлага хангасан асуултын тоо: | /........./........................./ | /........./........................./ |
| Шаардлага хангаагүй нийт оноо: | /........./........................./ | /........./........................./ |
| Хууль сахин мөрдөлтийн хувь: | /........./........................./ | /........./........................./ |
| Эрсдэл үүсэх магадлалын хувь: | /........./........................./ | /........./........................./ |
| Эрсдэл үүсэх магадлал: | *| их, дунд, бага |* | *| их, дунд, бага |* |

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

| № | Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт | Асуултууд | Батлагдсан оноо | | Авсан оноо | Гүйцэтгэлийн хяналт шалгалт |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Шаардлага хангаагүй | Шаардлага хангасан | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ | | | | | | |
| 1 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 34 дүгээр зүйлийн 34.2.5 дахь заалт | Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн эсэх? | 0 | 10 | | |
| 2 | | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдсан эсэх? | 0 | 10 | | |
| 3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх? | 0 | 10 | | |
| 4 | Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө | Зааврын дагуу боловсруулсан эсэх? | 0 | 10 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах заавар"-ын 1.12 дахь хэсэгт | | | | | |
| 5 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.4 дэх хэсэгт | Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээгээр төлөвлөж, зарцуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 6 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 10.3.5, 10.3.6 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам"-ын 2 дугаар хавсралтын Хуулийн этгээдийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, 2 а, б, 3, 5 а, б, в, 6 г, 7, 8 а, б, 9 б, 10, 12 дугаар зүйл. | Хуулийн этгээд нь болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангасан эсэх? | 0 | 10 | | |
| 7 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ын 2 дугаар хавсралтын 1.4, 5.3.2, 5.3.3 дахь заалт | Болзошгүй гамшгийн үед өөрийн байгууллагад байгаа материал хэрэгслийг гаргаж зарцуулах нөөцтэй эсэх? | 0 | 10 | | |
| 8 | ОБЕГ-ын даргын 2016 оны А/75 дугаар тушаалын 2 дугаар хавсралт | "Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө"-тэй эсэх? | 0 | 10 | | |
| 9 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.3.7, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт | Гамшгаас хамгаалах сургалтыг тогтоосон хугацаанд зохион байгуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 10 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. | Болзошгүй гамшгийн үед дайчлагдан ажиллах танай байгууллагын ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг хангасан эсэх? | 0 | 10 | | |

| НИЙТ ОНОО | | | 0 | 100 | | |
|---|---|---|---|---|---|---|

| ИЛ УУРХАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ ХАВСРАЛТ-2 | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 5 дугаар зүйлийн "в" заалт | Уул уурхайн ажилтнууд нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшиг болон галын аюулгүй байдал, анхны тусламжийн сургалтад хамрагдсан байна. | 0 | 10 | | |
| 2 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 34 дүгээр зүйл | Уул уурхайн үйлдвэр, уурхай бүр гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч өөрийн онцлогт тохирсон "Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө" боловсруулан мөрдөж ажиллана. | 0 | 9 | | |
| 3 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 76 дугаар зүйл | Тэсэлгээний ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлын төсөл, паспортын дагуу "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн холбогдох заалтыг баримтлан хийж гүйцэтгэнэ. Тэсэлгээний ажлын төсөл, паспортод заасан зүйлс зөрчигдөх, өрөмдлөгийн ажил дуусаагүй, уул тээврийн машин механизм, тоног төхөөрөмжийг аюултай бүсийн хязгаараас гаргаагүй байх зэрэг урьдчилсан бэлтгэл ажил хангагдаагүй үед тэсэлгээний ажил явуулахыг хориглоно. | 0 | 9 | | |
| 4 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 120 дугаар зүйл | Уулын ажлын батлагдсан паспортгүйгээр экскаватораар ажил гүйцэтгэхийг хориглоно.<br>Уг паспортад доголын өндөр, ажлын талбайн өргөн, налуугийн хэмжээ, уул тээврийн машины тэнхлэгээс мөргөцгийн болон овоолгын ирмэг хүртэлх зай, нурах аюултай бүсийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг тусгахаас гадна экскаваторын болон тээврийн хэрэгслийн ажиллах зарчим, бүдүүвчийг харуулна. Догол мөргөцгийн байдалд өөрчлөлт гарсан үед паспортыг шинэчилнэ. | 0 | 9 | | |
| 5 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 233 дугаар зүйл | Ил уурхайн авто замын налуугийн хэмжээ нь техник, эдийн засгийн тооцоогоор, хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын дүрэм, зааврын шаардлагыг хангасан байхаар тогтоогдох | 0 | 7 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | | бөгөөд автомашины хувьд техник ашиглалтын баримт бичигт үндэслэн 8-12%, тракторын хувьд 15%-с тус тус ихгүй байна. Техник ашиглалтын баримт бичигт заасан болон бусад онцгой тохиолдолд автомашин ба тракторыг дээр дурдсан хэмжээнээс илүү хэвгийтэй замд ажиллуулахыг зөвшөөрөх ба аюулгүй байдлыг хангаж ажиллана. | | | | |
| 6 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 239 дүгээр зүйл | Авто замын дээд хэсгийн өргөн нь түүн дээр ажиллах автомашины төрөл, овор хэмжээ, хөдөлгөөний чиглэл зэргээс хамаарах бөгөөд зураг төслөөр тогтооно. Ил уурхайн тусгаарлах зурвасгүй сөрөг урсгалтай замд зөрөх автомашинуудын хоорондын болон машины гадна талын дугуйнаас замын ирмэг хүртэлх зайг техникийн хүчин чадлыг үндэслэн зураг төслөөр тогтооно.<br>Нэг урсгалтай замын зорчих хэсгийн өргөнийг тухайн уурхайд ашиглагдаж байгаа хамгийн том овортой тээврийн хэрэгслийн өргөнийг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй байгуулна.<br>Ил уурхайн сөрөг урсгалтай, байнгын замд тусгаарлах даланг ашиглагдаж байгаа хамгийн том овортой тээврийн хэрэгслийн дугуйны диаметрийн хоёрны нэгээс багагүй өндөртэй байгуулна.<br>Траншейн түр хэрэглэгдэх замын өргөн нь тээврийн хэрэгсэл явж өнгөрөх хэсгээс гадна 1,5 м-ээс багагүй зай үлдээж байх шаардлагыг хангасан байна.<br>Тайлбар: Тээврийн хэрэгсэл зөрөх боломжгүй нарийн замд автомашин ба тракторыг сөрөг урсгалтай ажиллуулах үед, ирж буй машиныг хүлээж өнгөрүүлэх зорилгоор замын 150 м тутамд автомашин зөрж болохуйцаар зорчих хэсгийг нь өргөсгөж зассан байна. | 0 | 7 | | |
| 7 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 440 дүгээр зүйл | 1000 В хүртэлх ба түүнээс их хүчдэлтэй суурин болон зөөврийн цахилгаан тоног | 0 | 7 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төхөөрөмж нь газардуулгын ерөнхий байгууламжтай байна. | | | | |
| 8 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 444 дүгээр зүйл | Уурхайн газардуулгын сүлжээний гадаад үзлэгийг дараах хугацаанд хийж байна. Үүнд:<br>а. уурхайн хэсэг, цехийн ээлжийн хяналтын ажилтан ээлж бүр;<br>б. уурхайн хэсэг, цехийн дарга цахилгаанч нар, долоо хоног бүр;<br>в. компанийн цахилгаан эрчим хүчний асуудал хариуцсан нэгжийн дарга сар бүр.<br>Үзлэгийн үр дүнгийн талаар шуурхай ажлын журналд бичиж тэмдэглэнэ.<br>Газардуулгын сүлжээний бүрэн бүтэн байдал алдагдаж тасарсан тохиолдолд цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн ажиллагааг яаралтай зогсоож газардуулгын байгууламжид засвар хийж хэвийн болгоно. | 0 | 7 | | |
| 9 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 454 дүгээр зүйл | Ил уурхай нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдах, хянах болон аюулгүй ажиллагааг хангах зориулалтын харилцаа холбоо, хяналт дохиоллын иж бүрэн хэрэгслээр тоноглогдсон байна. | 0 | 7 | | |
| 10 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 475 дугаар зүйл | Гадаргын ба гүний усны ундаргагүй ил уурхайд ч ус татах ажиллагааг төлөвлөсөн байна. | 0 | 7 | | |
| 11 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 476, 477 дугаар зүйл | Хур тунадаснаас үүсэлтэй гадаргын ус уурхайд орохоос сэргийлсэн суваг шуудуу, далан хаалтыг байгуулна.<br>Үерийн аюулаас сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ. | 0 | 7 | | |
| 12 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 488 дугаар зүйл | Ус татах төв байгууламжид ус хураагуур байна. Ус хураагуур нь далд шүүрүүлэх уурхайд 4 цаг, ил ус таталтад 3 цагийн хэвийн ундаргаас багагүй багтаамжтай байна. | 0 | 7 | | |
| 13 | Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн 654, 655 дугаар зүйл | Ил уурхайн ажилтныг чанарын шаардлагад нийцсэн ундны усаар хангах үүрэгтэй.<br>Хэрэглээний усанд шинжилгээ хийлгэж, зөвшөөрөл авсан байна. | 0 | 7 | | |
| НИЙТ ОНОО | | | 0 | 100 | | |

| ИЛ УУРХАЙН АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2 дугаар зүйл | | Үндсэн төлөвлөлт дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: | | | | |
| 1 | 2.2.1. дүгээр зүйл | Уурхайн товч танилцуулга, ямар ашигт малтмал олборлодог, ашиглалтын систем, бэхэлгээ, агааржуулалт, ус таталт, тохиолдож болзошгүй аюул, ослын тухай; | 0 | 4 | | |
| 2 | 2.2.2. дугаар зүйл | Шуурхай ажиллагааг зохион байгуулах хэсэг; | 0 | 4 | | |
| 3 | 2.2.3. дугаар зүйл | Ослын үеийн удирдагчийг томилсон тухай уурхайн даргын тушаал; | 0 | 4 | | |
| 4 | 2.2.4. дүгээр зүйл | Уурхайн аврах нэгж байгуулсан тухай даргын тушаал; | 0 | 4 | | |
| 5 | 2.2.5. дугаар зүйл | Аюул, ослын үед уурхайн инженер техникийн ажилтан, холбогдох мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг; | 0 | 4 | | |
| 6 | 2.2.6. дугаар зүйл | Аюул, осол гарсан тухай яаралтай мэдэгдэх байгууллага, хариуцлагатай ажилтны дэс дараалал, нэрс, утасны дугаар, гэрийн хаяг; | 0 | 4 | | |
| 7 | 2.2.7. дугаар зүйл | Аюул, осол тохиолдсон үед уурхайн ажилтнуудын үүрэг | 0 | 4 | | |
| 2.3 дугаар зүйл | | Ажлын зурагт дараах зургууд орно. Үүнд: | | | | |
| 8 | 2.3.1. дүгээр зүйл | Уурхайн барилга, байгууламж, зам, талбай, налуу ам, орц, гарц, Мөргөцөг, нөөц гарц, цахилгааныг залгах, салгах байгууламж, шугам хоолойн Байрлал, үндсэн машин, тоног төхөөрөмж, далан, шуудуу, цугларах талбайн Байрлалыг заасан уурхайн ерөнхий дэвсгэр зураг; | 0 | 4 | | |
| 9 | 2.3.2 дугаар зүйл | Уурхайн ус шүүрүүлэлтийн зураг; | 0 | 4 | | |
| 10 | 2.3.3 дугаар зүйл | Уурхайн гал түймрээс хамгаалах усан хангамжийн зураг; Энэ зурагт гал унтраах зориулалттай шугам, хоолой, тоног төхөөрөмж, гал түймрийн хаалт, хамгаалалт, агуулахын байрлал, даралттай усны хоолойн сүүлийн цэг дээрх даралт зэргийг дүрсэлнэ. | 0 | 4 | | |
| 11 | 2.3.4 дүгээр зүйл | Уурхайн цахилгаан хангамжийн зураг. | 0 | 4 | | |
| 2.4 дүгээр зүйл | | Хавсралт хэсэгт уурхайн аюулын эсрэг бэлэн байдлыг шалгасан акт (төрөл тус бүрээр), комиссын дүгнэлтийг хавсаргасан байна. | | | | |
| 12 | Уурхайн доголын өндөр, ажлын ба ажлын бус налуу, хажуугийн өнцөг, тавцан, блокоос гарах гарцуудыг шалгасан АКТ | | 0 | 4 | | |
| 13 | Ажилтнууд ажлын байрнаасаа аюулгүй газарт очих | | 0 | 4 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хугацааг шалгасан АКТ | | | | |
| 14 | Уурхайн аюул тохиолдсон ажлын байранд аврах багийн очих хугацааг шалгасан АКТ | 0 | 4 | | |
| 15 | Уурхайн аюулын дохиолол, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн ажиллагаа, ажилтнуудын дохиогоор ажиллаж төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгасан АКТ | 0 | 4 | | |
| 16 | Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тэдгээрийн иж бүрдэл, хадгалалт, ашиглалтын бэлэн байдлыг шалгасан АКТ | 0 | 4 | | |
| 17 | Уурхайн гүний ус шүүрүүлэх насосын ажиллагааг шалгасан АКТ | 0 | 4 | | |
| 18 | Уурхайн аврах нэгжийг шалгасан АКТ | 0 | 4 | | |
| 19 | Уурхайн аюул, ослын үед хариу арга хэмжээ, бэлэн байдлын дүгнэлт | 0 | 4 | | |
| 20 | Үүсэж болзошгүй аюул ослын хувилбар боловсруулсан байдал | 0 | 4 | | |
| 21 | Уурхайн бүх хэсгүүдэд аюул, осол гарсан тухай мэдээлэх журам; | 0 | 5 | | |
| 22 | Ослын голомтоос хүмүүсийг гаргах зам; | 0 | 5 | | |
| 23 | Аюул, ослын үед цахилгаан гүйдлийг бүрмөсөн буюу хэсэгчлэн таслах арга хэмжээ; | 0 | 5 | | |
| 24 | Аюул, ослын үед тусгай үүрэг гүйцэтгэх ажилтныг томилж, аюулгүй байдлыг сахиулах, бүртгэх, хяналт тавих. | 0 | 5 | | |
| | НИЙТ ОНОО | 0 | 100 | | |

Шаардлага хангаагүй нийт оноо:

| | |
|---|---|
| >=50% | Их эрсдэлтэй |
| [30%-49%] | Дунд эрсдэлтэй |
| <=29% | Бага эрсдэлтэй |

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

| Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг | Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| (албан тушаал) | (албан тушаал) | (албан тушаал) |
| (овог, нэр) | (овог, нэр) | (овог, нэр) |
| (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) |

ТАЙЛБАР:

...........................................................................................................................................................
...........................................................................................................................................................
...........................................................................................................................................................
.................

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025... оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
А/404 дүгээр тушаалын 03 дугаар хавсралт

## АШИГТ МАЛТМАЛЫГ БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

### 1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

| | | |
|---|---|---|
| Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж: | | |
| Шалгуулагч этгээдийн нэр: | | |
| Регистрийн дугаар: | | |
| Объектын нэр, хаяг, солбицол: | | |
| Байгуулагдсан огноо: | | |
| Үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоо: | | |
| Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар: | | |
| Хяналт шалгалт хийсэн огноо: | Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн огноо: | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо: |
| | | |
| Шаардлага хангасан асуултын тоо: | /......../......................../ | /......../......................../ |
| Шаардлага хангаагүй нийт оноо: | /......../......................../ | /......../......................../ |
| Хууль сахин мөрдөлтийн хувь: | /......../......................../ | /......../......................../ |
| Эрсдэл үүсэх магадлалын хувь: | /......../......................../ | /......../......................../ |
| Эрсдэл үүсэх магадлал: | *I их, дунд, бага I* | *I их, дунд, бага I* |

### 2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

| № | Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт | Асуултууд | Батлагдсан оноо: Шаардлага хангаагүй | Батлагдсан оноо: Шаардлага хангасан | Авсан оноо | Гүйцэтгэлийн хяналт шалгалт |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | **ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ** | | | | | |
| 1 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 34 дүгээр зүйлийн 34.2.5 дахь заалт | Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн эсэх? | 0 | 10 | | |
| 2 | | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдсан эсэх? | 0 | 10 | | |
| 3 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй эсэх? | 0 | 10 | | |
| 4 | Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас | Зааврын дагуу боловсруулсан эсэх? | 0 | 10 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.12 дахь хэсэгт | | | | | |
| 5 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.4 дэх хэсэгт | Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээгээр төлөвлөж, зарцуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 6 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 10.3.5, 10.3.6 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам"-ын 2 дугаар хавсралтын Хуулийн этгээдийн бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлтийн хүснэгтийн 1а, б, г, 2 а, б, 3, 5 а, б, в, 6 г, 7, 8 а, б, 9 б, 10, 12 дугаар зүйл. | Хуулийн этгээд нь болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангасан эсэх? | 0 | 10 | | |
| 7 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ын 2 дугаар хавсралтын 1.4, 5.3.2, 5.3.3 дахь заалт | Болзошгүй гамшгийн үед өөрийн байгууллагад байгаа материал хэрэгслийг гаргаж зарцуулах нөөцтэй эсэх? | 0 | 10 | | |
| 8 | ОБЕГ-ын даргын 2016 оны А/75 дугаар тушаалын 2 дугаар хавсралт | "Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө"-тэй эсэх? | 0 | 10 | | |
| 9 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.3.7, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт | Гамшгаас хамгаалах сургалтыг тогтоосон хугацаанд зохион байгуулсан эсэх? | 0 | 10 | | |
| 10 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. | Болзошгүй гамшгийн үед дайчлагдан ажиллах танай байгууллагын ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг хангасан эсэх? | 0 | 10 | | |
| | НИЙТ ОНОО | | 0 | 100 | | |

| АШИГТ МАЛТМАЛЫГ БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС ХАВСРАЛТ-3 | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.2, 35.3.4 дэх заалт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын 3.3, 3.6, 3.10 дахь заалтууд | Эрх бүхий байгууллагаар (ЭБМЗ) хэлэлцүүлж батлуулсан техник эдийн засгийн үндэслэл | 0 | 4 | | |
| 2 | | Эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулсан уулын ажлын төлөвлөгөө | 0 | 4 | | |
| 3 | | Эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй эсэх | 0 | 4 | | |
| 4 | Ашигт малтмалын тухай хууль 35.4, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын 3.1 дэх заалт | Үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акттай эсэх | 0 | 4 | | |
| 5 | Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.7 дахь заалт | Ус ашиглах тухай гэрээ, Газар ашиглах тухай гэрээ эсэх | 0 | 4 | | |
| 6 | УУХҮЯ-ны сайдын 2019 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын 3.5, 4.8.13 дахь заалт | Үйлдвэрийн үндсэн түүхий эдийг худалдан авах гэрээтэй эсэх | 0 | 4 | | |
| 7 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, | Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй эсэх | 0 | 4 | | |
| 8 | Газрын хэвлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2019 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын 5.1, 5.2 дахь заалтууд | Баяжуулах үйлдвэрийн технологийн хаягдлыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх зорилгоор технологийн дотоод хяналт сорьцлолтыг тогтмол хийдэг эсэх | 0 | 4 | | |
| 9 | | Хөндлөнгийн технологийн хяналт сорьцлолтыг мэргэжлийн байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа гүйцэтгүүлдэг эсэх | 0 | 4 | | |
| 10 | Техник, эдийн засгийн үндэслэл | Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан технологийн дагуу үйл ажиллагаа явуулдаг эсэх | 0 | 4 | | |
| 11 | | Үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж зураг төслийн дагуу байршуулагдсан | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | эсэх | | | | |
| 12 | | Эрдсийн бүрэн шинжилгээний нарийвчилсан үр дүнтэй эсэх | 0 | 4 | | |
| 13 | | Ус, шламын тооцоо зураг, төсөлд тусгагдсаны дагуу эсэх | 0 | 4 | | |
| 14 | | Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт зураг, төсөлд тусгагдсаны дагуу байгаа эсэх | 0 | 4 | | |
| 15 | | Үйлдвэрийн хаягдлын аж ахуйн байгууламж зураг, төсөлд тусгагдсаны дагуу байгаа эсэх | 0 | 4 | | |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/155, А/132 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм | | | | | | |
| 16 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 41, 162 дахь заалтууд | Ажлын байрны аюул учирч болзошгүй газарт автомат дуут болон гэрлэн дохиоллын системээр тоноглогдсон эсэх | 0 | 4 | | |
| 17 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 39 дэх заалт | Ажлын бүх байрыг зохих нормын дагуу гэрэлтүүлэгдсэн эсэх | 0 | 4 | | |
| 18 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 25 дахь заалт | Бүх төрлийн ажлын талбай, гүүр, суваг, шатнууд нь бат бэх 1 м-ээс багагүй өндөртэй хашлагатай, хашлаганы доод талаар 0.14 м өндөр хөндлөвч хаалт хийгдсэн эсэх | 0 | 4 | | |
| 19 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 26 дахь заалт | Тоног төхөөрөмж болон ажлын талбайд хэрэглэх шатны налуу 45°-аас ихгүй хийгдсэн эсэх | 0 | 4 | | |
| 20 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 228, 229 дэх заалтууд | Технологийн дамжлагад шингэн урвалжийг механик аргаар өгдөг эсэх, Технологийн сорьцлолтыг зөвхөн зориулалтын цэгээс, механик аргаар дээж авдаг эсэх | 0 | 4 | | |
| 21 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 125 дахь заалт | Механизмуудын эргэлдэгч эд ангиуд нь битүү буюу 25x25 мм, конвейерийн хүрдний торон хаалт нь 40x40 мм-ээс ихгүй хэмжээтэй хаалт хамгаалалттай эсэх | 0 | 4 | | |
| 22 | Газрын хэвлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт | Ашигт бүрдэл хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрийн хаягдлыг | 0 | 4 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэж, хадгалж хамгаалдаг эсэх | | | | |
| Флотацийн болон уусган баяжуулах | | | | | | |
| 23 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 152 дахь заалт | Химийн бодис болон урвалжийг хадгалахдаа “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах”-ын стандартыг мөрдөн ажилладаг эсэх | 0 | 3 | | |
| 24 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 139 дэх заалт | Үйлдвэр нь хор аюулын лавлахтай байх бөгөөд урвалжтай харьцаж ажилладаг ажилтан лавлахтай танилцсан эсэх | 0 | 3 | | |
| Цианидаар уусган баяжуулах | | | | | | |
| 25 | Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн 265, 266 дахь заалтууд | Онцгой хортой хий ялгаруулдаг үйлдвэрт хийн алдагдал илрүүлэгч хувийн хэмжих багажаар хангадаг эсэх | 0 | 3 | | |
| 26 | | Цианжуулах хэсгийн ажилтан цианидын уусмалтай шууд харьцахаас сэргийлсэн, тоног төхөөрөмж ба сав нь битүүмжлэл сайтай, агааржуулалтын системээр тоноглогдсон эсэх | 0 | 3 | | |
| НИЙТ ОНОО | | | 0 | 100 | | |

Шаардлага хангаагүй нийт оноо:

| | |
|---|---|
| >=50% | Их эрсдэлтэй |
| [30%-49%] | Дунд эрсдэлтэй |
| <=29% | Бага эрсдэлтэй |

## 3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

| Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг | Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг | Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| (албан тушаал) | (албан тушаал) | (албан тушаал) |
| (овог, нэр) | (овог, нэр) | (овог, нэр) |
| (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) | (гарын үсэг, тэмдэг) |

ТАЙЛБАР:
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
..................

---oOo---